УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

ПАРЛАМЕНТЫН
СУДАЛГАА
СУРГАЛТЫН
ХҮРЭЭЛЭН

# ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗАРИМ АСУУДЛААРХ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Харьцуулсан судалгаа
Судалгааны код: СТ-24/202


Захиалагч: УИХ-ын дарга Г.Занданшатар

Судлаачид: Г.Билгээ, Э.Дашзэгвэ, Э.Билгүүн, Б.Мөнгөнсувд, О.Нарантуяа, Х.Очир Т.Эрдэнэчимэг



Улаанбаатар
2024 он

# АГУУЛГА

УДИРТГАЛ ..... 3
СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ ..... 4
СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ХЭСЭГ ..... 10
ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗАРИМ АСУУДЛААРХ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА ..... 10
1.АВСТРАЛИЙН ХОЛБООНЫ УЛС ..... 10
2.ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛС ..... 13
3.КАНАД УЛС ..... 15
4.БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС ..... 18
5. НИДЕРЛАНДЫН ХААНТ УЛС ..... 21
6. НОРВЕГИЙН ХААНТ УЛС ..... 23
ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ ..... 26

## УДИРТГАЛ

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарын захиалгаар “Гадаадын хөрөнгө оруулалтын зарим асуудлаарх харьцуулсан судалгаа” сэдэвт судалгааг Парламентын судалгаа, сургалтын хүрээлэнд гүйцэтгэв.

***Судалгааны зорилго:*** Гадаадын зарим орны хөрөнгө оруулалтын эрх зүйн орчин, түүн дотроо гадаадын хөрөнгө оруулагчид тавигдах нөхцөл, шалгуур, гадаадын хөрөнгө оруулалтын босго хэмжээ, хязгаарлалт, хөрөнгө оруулалтын урамшуулал, дэмжлэг болон бусад асуудлыг харьцуулан судлах.

***Судалгааны хамрах хүрээ:*** Энэхүү судалгаанд захиалагчийн хүсэлтийн дагуу Австрали, ХБНГУ, Канад, БНСУ, Нидерланд, Норвег зэрэг улсын гадаадын хөрөнгө оруулагч нарт тавьж буй нөхцөл, шаардлага, хөрөнгө оруулалтын доод хэмжээ, хязгаарлалт, урамшуулал, дэмжлэг, гадаадын хөрөнгө оруулагч, түүний гэр бүлд олгох визийн болон бусад хөнгөлөлтийн талаарх асуудлыг тэдгээр орнуудын хууль, эрх зүйн орчны хүрээнд харьцуулан судалсан болно

***Судалгааны бүтэц:*** Судалгаа нь хураангуй болон үндсэн хэсэгтэй. Судалгааны үндсэн хэсэгт, судалгаанд авагдсан улс орнуудын гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн зохицуулалтын талаарх мэдээллийг судалсан болно.

***Түлхүүр үг:*** *Хөрөнгө оруулалт, гадаадын хөрөнгө оруулалт, хөрөнгө оруулалтын урамшуулал, хөрөнгө оруулалтыг дэмжих*

***Key words:*** *Investment, Foreign Investment, Investment incentive, invesment promote*

## СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Энэхүү судалгаанд хамрагдсан Австрали, ХБНГУ, Канад, БНСУ, Нидерланд, Норвег зэрэг улсын гадаадын шууд хөрөнгө оруулалтын харилцааг зохицуулсан хууль, эрх зүйн орчин нь тухайн улсынхаа түүхэн уламжлал, нөхцөл, эдийн засгийн хүчин чадавх, шинжлэх ухаан, технологийн хөгжлийн түвшин зэргээсээ хамааран харилцан адилгүй байна.

Хууль эрх зүйн орчны хувьд зарим улсад гадаадын хөрөнгө оруулалт (ГХО)-ыг бие даасан тусгай хуулиар зохицуулдаг бол зарим улсад гадаад, дотоод гэж ялгалгүйгээр хөрөнгө оруулалтын нэгдмэл хуулиар зохицуулдаг, мөн зарим улсад үндэсний аюулгүй байдлын, өрсөлдөөний, санхүүгийн зэрэг бусад хууль тогтоомжоор зөвхөн зарим асуудалд хяналт тавих болон тодорхой хязгаарлалт тогтоох байдлаар зохицуулалт хийсэн байна.

Гадаадын хөрөнгө оруулагчид тавьж буй нөхцөл, шалгуурын тухайд мөн л улс орон бүр харилцан адилгүй тодорхойлсон боловч ихэнх улсад хөрөнгө оруулалтын доод хэмжээг тогтоосон байна. Нидерланд, Норвег зэрэг улсууд гадаадын болон дотоодын хөрөнгө оруулагчдад адил тэгш хандах зарчимд суурилсан нээлттэй, чөлөөт орчинтой бөгөөд ГХО-д тусгай зөвшөөрөл, нөхцөл, шалгуур шаарддаггүй.

Гэвч сүүлийн үеийн олон улсын хурцадмал нөхцөл байдал, терроризм, мөнгө угаах зэрэг дэлхий дахины тулгамдсан асуудлуудаас үүдэн үндэсний аюулгүй байдлыг хангах шаардлагаар ГХО-ын хяналт, бүртгэлийн шалгуур, механизмаа дийлэнх улс орнууд чангатгаж байна. Тухайлбал, ГХО-д хамгийн чөлөөт, нээлттэй тогтолцоотой Норвег Улсад үндэсний аюулгүй байдалд хамааралтай гэж үзвэл тус улсын аль ч салбарын, ямар ч компанийн хувьцаа, ногдол хувийг худалдах, шилжүүлэх (хөрөнгө оруулах) асуудалд тус улсын эрх бүхий байгууллагууд хөндлөнгөөс оролцох, тухайн хөрөнгө оруулалтаас татгалзах, хэлцлийг зогсоох эрхтэй байх хуулийн өөрчлөлтийг 2023 онд хийжээ.

Судалгаанд хамрагдсан улс орнуудад гадаадын иргэд, аж ахуйн нэгж (ААН)-үүд газар, үл хөдлөх хөрөнгийг ямар нэгэн байдлаар эзэмшиж, ажиллаж болох боловч ГХО-тай холбоотойгоор зохих хязгаарлалтууд тогтоосон байна. Жишээлбэл, Австрали Улсад нийтийн эзэмшлээс бусад газарт гадаадын хөрөнгө оруулагч тодорхой хэмжээний газрын төлбөр төлөх байдлаар тухайн газрыг эзэмшиж ашиглаж болдог бол Норвег Улсад ой мод бүхий газар, уурхайн эдэлбэр газар, тариалангийн газар, хүрхрээ, усан сан бүхий газрын эзэмших, ашиглах эрхийг зөвхөн концессын нөхцөлөөр ашиглуулдаг ба бусад газар, үл хөдлөх хөрөнгийг эзэмшиж ашиглахыг зөвшөөрдөг. Харин Нидерланд Улс гадаадын хөрөнгө оруулагч нарт үл хөдлөх хөрөнгө, тэр дундаа газар эзэмших, ашиглахад ямар нэгэн хязгаарлалт, хориглолт тогтоодоггүй байна.

Судалгаанд хамрагдсан орнуудын зарим онцлох асуудал, зохицуулалтуудыг дурдвал:

**Австралийн Холбооны Улс:** Гадаадын хөрөнгө оруулагчдад хөрөнгө оруулалтын хэмжээг хувь хүн болон ААН, мөн гадаад улсын төрийн өмчит компани гэсэн шалгууруар өөр өөр босго тогтоосон байна. Гадаадын хөрөнгө оруулагчид бизнесийн төрөл, үйл ажиллагааны чиглэлээр хуулийн тодорхой шалгуурыг давсан тохиолдолд цахимаар хүсэлтээ гаргах боломжтой. Холбогдох хөрөнгө оруулалтын хэмжээ нь хөрөнгө оруулагч нь хэн болох, хөрөнгө оруулагч нь аль улсаас гаралтай зэрэг хүчин зүйлсээс хамаарах хэдий ч ихэнх хөрөнгө оруулагчдад тавьдаг стандарт хэмжээ нь гадаадын хувийн хөрөнгө оруулагчдын Австрали Улс дахь хөгжингүй худалдааны нутаг дэвсгэрт хөрөнгө оруулахад тогтоосон 15-275 сая австрали доллар байдаг. Мөн газар эзэмших, ашиглахтай холбоотойгоор тухайн мөнгөн дүнгийн хэмжээ өсдөг байна.

Тухайлбал, тус улсын хөдөө аж ахуйн салбарт хөрөнгө оруулах босго нь 15 сая австрали доллар байна. Хэрэв чөлөөт худалдааны гишүүн орны бизнес эрхлэгч бол хөрөнгө оруулалтын доод хэмжээний шалгууруас дээгүүр хөрөнгө оруулдаг.

**Холбооны Бүгд Найрамдах Герман Улс:** ХБНГУ-д хувиараа бизнес эрхлэх (self-employment), хөрөнгө оруулалт хийхэд хамгийн доод хэмжээг заагаагүй хэдий ч албан бус мэдээллээр тухайн ААН-ийн хөрөнгө оруулалтын хэмжээ нь 360,000 евро байх ба дараах шаардлагыг хангасан байна: 1) тус улсад хийх бизнесийн зорилгоо тодорхойлсон байх, бизнесийн төлөвлөгөө гаргасан байх, эрсдэлийн үнэлгээ хийсэн байх; 2) тухайн бизнес нь тус улсын эдийн засгийн сонирхолд нийцсэн байх, муж улсын хэрэгцээ шаардлагыг хангасан байх; 3) тухай ААН-ийн ажилчдын тоо хамгийн багадаа 5 байх зэрэг болно.

**Канад Улс:** Тус улсад хөрөнгө оруулалтын хуулийн хэрэгжилтийг Канадын Улсын инновац, шинжлэх ухаан, эдийн засгийн хөгжлийн газар хариуцдаг байна. Мөн Захиргааны зөвлөл нь үндэсний аюулгүй байдлыг хангах, хяналт шалгалт хийх байгууллагуудтай хамтран ажиллах, хуулийн хэрэгжилтийг хангах зэрэг чиг үүрэгтэй.[1] Харин Соёлын салбартай холбоотой хөрөнгө оруулалтыг Канадын өвийн хэлтэс хариуцдаг байна.

Канад Улсын Инновац, шинжлэх ухаан, эдийн засгийн хөгжлийн сайд Үндэсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй хөрөнгө оруулалтыг Захиргааны зөвлөлд шилжүүлж хяналт, шалгалт хийх үүрэг хүлээнэ. Хяналт, шалгалт хийсний дараагаар Үндэсний аюулгүй байдалд хохирол учруулах магадлалтай тохиолдолд хөрөнгө оруулалтыг татгалзах, эсхүл заасан нөхцөл, болзлыг хэрэгжүүлэх шаардлага тавих эрхтэй.

**Бүгд Найрамдах Солонгос Улс:** Гадаадын хөрөнгө оруулагчдад зориулсан оршин суух D-8 визийг олгодог. Тус визийг Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих тухай хуульд заасан шаардлага хангасан ГХО-тай компанийн удирдлага, үйлдвэрлэл, технологи болон техникийн өндөр ур чадвартай мэргэжилтнүүд, үйлдвэрлэлийн болон оюуны өмчийн эрх эзэмшигчдэд олгодог.

Хөрөнгө оруулагчийн D-8 визтэй гадаадын иргэдийг дагалдан яваа гэр бүлийн гишүүд хөрөнгө оруулагчийн виз, оршин суух хугацаатай ижил байна.

**Нидерландын Хаант Улс:** Тус улсад оруулсан хөрөнгө оруулалт нь Нидерландын эдийн засагт нэмүү өртөг бүтээж байх ёстой гэж үздэг. Аливаа хөрөнгө оруулалт нь дараах 3 шалгуурын 2-ыг хангаж буй тохиолдолд нэмүү өртөг бүтээж байна гэж үзнэ. Үүнд: 1) 5 жилийн дотор 10-аас доошгүй ажлын байр бий болгох; 2) Нидерланд Улсын компанийн шинэлэг байдлыг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулсан байх. Үүнийг патент нэвтрүүлэх, технологийн болон технологийн бус шинэлэг зүйлд хөрөнгө оруулалт хийх, эсхүл шилдэг салбарт хамаарах компанид хөрөнгө оруулах зэргээр нотолж болно; 3) Тодорхой мэдлэг, сүлжээ, үйлчлүүлэгчид, хөрөнгө оруулагчийн идэвхтэй оролцоо гэх мэт өөр нэг санхүүгийн бус нэмүү өртөгтэй байх зэрэг болно.

**Норвегийн Хаант Улс:** Тус улсын хууль тогтоомжоор гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг тухайлан ялгадаггүй бөгөөд хөрөнгө оруулалтад зарим нэг хязгаарлалт тогтоосон байдаг боловч тэдгээр нь гадаадын шууд хөрөнгө оруулагч нарт тусгайлан чиглэдэггүйгээрээ онцлогтой байна. Гадаад, дотоодын иргэний харьяалал харгалзахгүйгээр тодорхой салбарын хөрөнгө оруулалтад ерөнхий хязгаарлалт буюу концессын шаардлага тавьдаг. Цаашлаад үндэсний аюулгүй байдлын эрх ашиг, өрсөлдөөний хуулийн зохицуулалтаас шалтгаалсан нарийвчилсан хязгаарлалтууд ч бий. Жишээлбэл: Аж үйлдвэрийн хамгийн чухал салбар болох газрын тос, байгалийн хийн салбарт Норвег Улсын газрын тосны лиценз эзэмшигч хуулийн этгээдийн ногдол хувь, хувьцааг худалдан авахад зөвхөн тус улсын Засгийн газрын

[1] Канад Улсын хөрөнгө оруулалтын тухай хуулийн 35-р зүйл.

зөвшөөрлөөр хийгддэг боловч энэ шаардлага нь гадаадын шууд хөрөнгө оруулалтад тусгайлан чиглэгддэггүй, дотоодын худалдан авагчдад мөн адил хамаардаг. Мөн түүнчлэн загас агнуурын хөлөг онгоц эсхүл далайн хөлөг онгоц эзэмшдэг компанийн ногдол хувь, хувьцааг зөвхөн Норвег Улсын иргэн болон Норвег иргэдийн өмчлөлийн ААН худалдан авах эрхтэй байдаг зэрэг хязгаарлалтууд буй.

Норвег Улсад гадаадын хөрөнгө оруулагчид газрыг оролцуулаад үл хөдлөх хөрөнгө эзэмшиж болно. Гэсэн хэдий ч тодорхой төрлийн үл хөдлөх хөрөнгийн өмчлөлийг хязгаарласан байдаг. Ой мод, уурхай, тариалангийн газар, хүрхрээ эзэмших, ашиглах эрхийг зөвхөн концессоор л авах боломжтой. Түрээсийн гэрээ нь 10 жилээс хэтрэхгүй бол гадаадын компаниудад арилжааны байгууламж, оффисын байр зэрэг үл хөдлөх хөрөнгө түрээслэхэд концессын хөнгөлөлт үзүүлэхгүй.

(*Дэлгэрэнгүйг Хүснэгт 1-ээс харна уу.*)

**Хүснэгт 1. Гадаадын хөрөнгө оруулалтын зарим асуудлаарх харьцуулсан хүснэгт**

| | Австрали | Герман | Канад | Өмнөд Солонгос | Нидерланд | Норвег |
|---|---|---|---|---|---|---|
| **Эрх зүйн орчин** | -Үндсэн хууль;<br>-Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль;<br>-Гадаадын хөрөнгө оруулалтын хураамжийн тухай хууль;<br>-Гадаадын хөрөнгө оруулалтын тухай журам. | -Гадаадын худалдаа, төлбөр, тооцооны тухай хууль;<br>-Гадаадын худалдаа, төлбөр, тооцооны журам. | -Канад Улсын хөрөнгө оруулалтын тухай хууль. | -Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих тухай хууль. | -Хөрөнгө оруулалт, хуулийн этгээдийн нэгдэл, худалдан авалтын тухай хууль (Vifo Act). | Гадаадын хөрөнгө оруулалтын бие даасан, тусгай хууль байдаггүй.<br>-Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 10 дугаар бүлэг (Өмчлөлийн хяналт);<br>-Өрсөлдөөний тухай хууль. |
| **Гадаадын хөрөнгө оруулагчид тавигдах нөхцөл, шаардлага** | Нээлттэй бодлого баримталдаг ч Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулиараа тусгай шалгуур, хөрөнгө оруулалтын доод хэмжээ (15-275 сая австрали доллар) тогтоож, зохих зөвшөөрөл шаарддаг.<br>Үндэсний аюулгүй байдалд харшлах салбарт хөрөнгө оруулалтын тусгай журам шалгуур мөрдөнө. Стратегийн үйлдвэрлэл, газар, харилцаа холбоо, хэвлэл мэдээлэл, уул уурхайн хайгуул, цөмийн энергийн салбарт хөрөнгө оруулалтын хэмжээ болон бусад босго тогтоосон. | Гадаад улсаас тус улсад хувиараа бизнес эрхлэх, хөрөнгө оруулалт хийх доод хэмжээг заагаагүй ч тухайн ААН-ийн хөрөнгө оруулалтын жишиг хэмжээ нь 360,000 евро байдаг бөгөөд дараах шаардлагыг хангана:<br>-тус улсад хийх бизнесийн зорилгоо тодорхойлсон байх, бизнесийн төлөвлөгөө гаргасан байх, эрсдэлийн үнэлгээ хийсэн байх;<br>-тухайн бизнес нь тус улсын эдийн засгийн сонирхолд нийцсэн байх, муж улсын хэрэгцээ шаардлагыг хангасан байх;<br>-тухай ААН-ийн ажилчдын тоо хамгийн багадаа 5 байх. | Хөрөнгө оруулалтыг хэмжээ 100,000-аас 350,000 канад долларын (CAD) хооронд хэлбэлзэнэ.<br>Тавигдах шаардлага:<br>-нарийвчилсан бизнес төлөвлөгөөтэй байх;<br>-бизнесийн туршлага, ур чадвартай байх;<br>-Канад Улсад бизнес эрхлэх чин хүсэлтэй байх;<br>-хөрөнгө оруулагчдад виз олгох цагаачлалын хөтөлбөрийн шалгуурыг хангасан байх.<br>Канад Улсын Захиргааны зөвлөл нь үндэсний аюулгүй байдалтай холбоотойгоор ГХО-ыг хянана. | Гадаадын шууд хөрөнгө оруулалт гэж хөрөнгө оруулалтын хэмжээ 100 сая вон ба түүнээс дээш, ГХО-ын харьцаа 10 хувь ба түүнээс дээш бол гадаадын иргэн БНСУ-д тусгай зохицуулалтаас бусад тохиолдолд хязгаарлалтгүй бизнес эрхлэх боломжтой.<br>Хөрөнгө оруулалтын төрөлд дотоодын компанийн хувьцааг худалдан авах, гадаад дахь толгой компаниас 5 ба түүнээс дээш жилийн хугацаатай урт хугацаатай зээл авах, шинжлэх ухаан, технологийн чиглэлээр ашгийн бус корпорацуудад хөрөнгө оруулах зэрэг багтана.<br>Тус улсад гадаадын шууд хөрөнгө | Нидерланд Улс нь хөрөнгө оруулах зохих шаардлагуудыг тавих бөгөөд, чухал үйлчилгээ үзүүлэгч болон эмзэг технологитой компаниудад хөрөнгө оруулахад маш хатуу хяналт тавина.<br>Оруулсан хөрөнгө оруулалт нь Нидерланд Улсын эдийн засагт нэмүү өртөгтэй байх. Хөрөнгө оруулалт нь дараах 3 шалгуурын 2-ыг хангасан тохиолдолд нэмүү өртөгтэй гэж үзнэ:<br>1.5 жилийн дотор 10-аас доошгүй ажлын байр бий болгох.<br>2.Нидерланд Улсын компанийн шинэлэг байдлыг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулсан байх. | Ерөнхийдөө Норвег Улсын хөрөнгө оруулалтын дэглэм нь гадаадын болон дотоодын хөрөнгө оруулагчдад адил тэгш хандах зарчимд суурилдаг, нээлттэй, чөлөөт (liberal) тогтолцоотой тул ГХО-д тусгай зөвшөөрөл шаарддаггүй.<br>Тус улсад гадаад, дотоодын харьяалал харгалзахгүйгээр тодорхой салбарын хөрөнгө оруулалтад ерөнхий хязгаарлалт буюу концессын шаардлага тавьдаг.<br>Цаашлаад үндэсний аюулгүй байдлын эрх ашиг, өрсөлдөөний хуулийн зохицуулалтаас шалтгаалсан зарим салбарт нарийвчилсан хязгаарлалт байдаг. |

| | Австрали | Герман | Канад | Өмнөд Солонгос | Нидерланд | Норвег |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | оруулалтыг хязгаарласан хязгаарлалт байхгүй ч зарим салбарт ГХО-ыг тодорхой хувиар хязгаарладаг. | 3.Санхүүгийн бус нэмүү өртөгтэй байх. | |
| **Газар эзэмших, ашиглах** | Тодорхой хөрөнгө оруулалтын доод хэмжээ тавьж газрыг ашиглах, эзэмших эрхийн зөвшөөрлийг холбогдох төрийн байгууллагаас олгодог.<br>Гадаадын хөрөнгө оруулагчид тус улсад газар эзэмших, ашиглах тохиолдолд мөн тодорхой хуулийн шалгуур, хөрөнгө оруулалтын доод хэмжээ (330 саяас - 1 тэрбум 427 сая австрали доллар) тавьсан байдаг. | Гадаадын иргэн, хөрөнгө оруулагч тус улсад газар эзэмшихэд хатуу хязгаарлалт тавьдаггүй, харьцангуй нээлттэй бодлого баримталдаг. | Гадаадын хөрөнгө оруулагчид тус улсын нутаг дэвсгэрийг 20 хүртэлх жилээр, 20 хүртэлх акр (acre) хэмжээтэй 2 хүртэлх газрыг түрээслүүлнэ. | БНСУ-д гадаадын хөрөнгө оруулагчид тус улсын иргэдтэй адил ялгаварлалгүйгээр үл хөдлөх хөрөнгө худалдан авч болно.<br>Цогцолбор хэлбэрийн ГХО-ын бүс нь зөвхөн гадаадын хөрөнгө оруулагч компаниудад тусгайлан түрээслэх, шилжүүлэхэд зориулагдсан бүс юм. Түрээсийн хугацаа 50 жил байх ба 10 жил тутамд сунгах гэрээ байгуулах ёстой. Энэ бүс рүү шилжиж буй компаниудад хөрөнгө оруулалтаас хамааран түрээсийн хөнгөлөлт, татварын хөнгөлөлт үзүүлдэг. | Гадаадын иргэдэд Нидерланд Улсад үл хөдлөх хөрөнгө худалдаж авах аливаа хязгаарлалт байхгүй. | Норвег Улсад гадаадын хөрөнгө оруулагчид үл хөдлөх хөрөнгө (газар) эзэмшиж болно. Гэсэн хэдий ч тодорхой төрлийн үл хөдлөх хөрөнгийн өмчлөлийг хязгаарласан байдаг. Ой мод, уурхай, тариалангийн газар, хүрхрээ эзэмших, ашиглах эрхийг зөвхөн концессоор л авах боломжтой. Түрээсийн гэрээ нь 10 жилээс хэтрэхгүй бол гадаадын компаниудад арилжааны байгууламж, оффисын байр зэрэг үл хөдлөх хөрөнгө түрээслэхэд концессын хөнгөлөлт үзүүлэхгүй. |
| **Гадаадын хөрөнгө оруулагч, түүний гэр бүлд визийн хөнгөлөлт үзүүлэх журам** | -Хамгийн багадаа 750.000 австрали долларын хөрөнгийн эргэлттэй, 1.25 сая австрали долларын хөрөнгөө нотолсон бол тус улсад **нэг жил оршин суух виз** олгоно;<br>-Австрали Улсын удирддаг хөрөнгө оруулалтын санд 2.5 сая австрали | ХБНГУ-д хөрөнгө оруулалт хийх, хөрөнгө оруулалтын виз авснаас хойш 3 жилийн дараа байнгын оршин суух, 8 жилийн дараа тус иргэн болох эрхтэй.<br>Виз мэдүүлэгч нь дараах шаардлагыг хангасан байна: | Холбооны болон мужийн хөрөнгө оруулалтын цагаачлалын хөтөлбөрөөр дамжуулан байнгын оршин суух, иргэншил авах боломжийг гадаадын хөрөнгө оруулагч болон түүний гэр бүлд олгодог. | Гадаадын хөрөнгө оруулагчдад зориулсан оршин суух D-8 визийг олгодог. Тус визийг ГХО-ыг дэмжих тухай хуульд заасан шаардлага хангасан ГХО-тай компанийн удирдлага, үйлдвэрлэл, технологи болон техникийн өндөр ур чадвартай мэргэжилтнүүд, | Энэ хөтөлбөр нь 3 жилийн хугацаатай, ажиллах эрхтэй түр оршин суух зөвшөөрлийг гадаадын хөрөнгө оруулагч болон гадаадын хөрөнгө оруулагчийн гэр бүлийн гишүүдэд олгоно.<br>Тус улсад 5 жил амьдарсан бол | Тус улсад хөрөнгө оруулагчийн виз, хөрөнгө оруулалтын иргэншил авах гадаадын иргэд, түүний гэр бүлийн гишүүд нь дараах үндсэн нөхцөлийг хангахыг шаарддаг:<br>-18 насанд хүрсэн байх; |

| | Австрали | Герман | Канад | Өмнөд Солонгос | Нидерланд | Норвег |
|---|---|---|---|---|---|---|
| | долларыг түр визний хүчинтэй байх хугацаанд төлсөн бол **оршин суух эрхийг 2 жилээр сунгана**;<br>-эдийн засгийн тэргүүлэх салбарт хөрөнгө оруулалт хийсэн, эрдэм шинжилгээ судалгаа, инновац хөгжүүлэх салбарт ажиллах мэргэжилтэнд **байнга оршин суух виз** олгоно. | -18 насанд хүрсэн байх;<br>-ял шийтгэл хүлээж байгаагүй;<br>-бизнесийн салбарт ажилласан туршлагатай байх;<br>-өөрийн хөрөнгө, эсхүл зээлийн амлалт гаргаж хөрөнгө оруулалтын сангаа баталгаажуулсан байх. | Хөрөнгө оруулагчид байнгын оршин суух эрхтэй 3 жил амьдарсны дараагаар иргэншил авах боломж бүрддэг. Иргэншил хүсэгч нь англи, эсхүл франц хэлний мэдлэгтэй байх бөгөөд гэмт хэргийн бүртгэлгүй байх шаардлагатай. | үйлдвэрлэлийн болон оюуны өмчийн эрх эзэмшигчдэд олгодог.<br>Хөрөнгө оруулагчийн D-8 визтэй гадаадын иргэдийг дагалдан яваа гэр бүлийн гишүүд хөрөнгө оруулагчийн виза, оршин суух хугацаатай ижил байна. | Нидерланд Улсын байнгын оршин суугч болох, эсхүл тус улсын паспорт авах боломжтой. | -гэмт хэрэг үйлдээгүй байх;<br>-100,000 евро ба түүнээс дээш хэмжээний хөрөнгө оруулалт хийсэн байх;<br>-шаардлага хангасан бизнест хөрөнгө оруулалт хийж, ажлын байр бий болгосон байх. |
| **Хөрөнгө оруулагчид олгох бусад төрлийн урамшуулал** | Татварын хөнгөлөлт:<br>Засгийн газар нь “Гадаад улсын Засгийн газрын хөрөнгө оруулагч” гэж ангилагдсан ААН-ийг тодорхой хөрөнгө оруулалтыг татвараас чөлөөлдөг. Энэ нь гадаадын засгийн газрын хөрөнгө оруулагчид нь тухайн ААН-ийн хөрөнгө оруулалт, эсхүл үйл ажиллагааны шийдвэр болон ААН-ийн үндсэн хөрөнгөд нөлөөлөл, хяналт байхгүй тохиолдолд хэрэгжинэ. | Хязгаарлагдмал хариуцлагатай компани (GmbH), эсхүл хувьцаат компани нь ХБНГУ-д төвтэй, эсхүл гүйцэтгэгч зөвлөлтэй бол олон улсад үйл ажиллагаа эрхэлж олсон орлогоос аж ахуйн нэгжийн татварыг төлөх үүрэгтэй. Харин олон улсад үйл ажиллагааг эрхэлж олсон ногдол ашгийг татвараас чөлөөлөх, өөр улсад татвараа төлсөн тохиолдолд ХБНГУ-д төлсөн татвараас нөхөх боломжтой.<br>ХБНГУ-д байрладаггүй, эсхүл гүйцэтгэгч зөвлөлгүй тохиолдолд зөвхөн тус улсад олсон орлогоос аж ахуйн нэгжийн албан татварыг төлнө. | -Иргэншил авсан тохиолдолд дэлхийн 197 орон руу чөлөөтэй зорьчих боломжтой<br>-Судалгаа, хөгжүүлэлтийн үйл ажиллагаа эрхэлдэг компаниудыг 15%-ийн буцаан олгогдохгүй татварын хөнгөлөлт эдэлнэ;<br>-Хорт бодис ялгаруулдаггүй технологи үйлдвэрлэгчдийн татварын хэмжээг 50 хувиар бууруулна;<br>-утааг бууруулах технологи, зай хураагуур зэрэг хөрөнгө оруулалтад 30 хүртэлх хувийн татварын хөнгөлөлт үзүүлнэ. | Тус улс гадаадын хөрөнгө оруулагчдад татварын болон түрээсийн хөнгөлөлт, байршлын дэмжлэг болон санхүүгийн дэмжлэг үзүүлдэг. | ГХО-ыг дэмжих хөтөлбөрт хамрагдсанаар гадаадын хөрөнгө оруулагч болон гадаадын хөрөнгө оруулагчийн гэр бүлийн гишүүд нь Европын Холбооны орнуудад визгүй зорчих эрхтэй болно. Цаашилбал, Нидерланд Улсын паспорттой болсноор дэлхийн 125 оронд визгүй зорчих эрхтэй болдог. | Тус улсад хөрөнгө оруулалтын урамшуулал нь татварын болон татварын бус хэлбэртэй. Татварын урамшуулал нь ерөнхий болон тодорхой тэргүүлэх салбарт чиглэсэн байдаг. Мөн хөрөнгө оруулагч нарт бизнес, санхүү, батлан даалтын зэрэг бусад дэмжих үйлчилгээ үзүүлдэг төрийн болон төрийн өмчит байгууллагууд байдаг байна. |

# ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗАРИМ АСУУДЛААРХ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

## 1.АВСТРАЛИЙН ХОЛБООНЫ УЛС

### Эрх зүйн орчин

Австралийн Холбооны Улс (Австрали Улс) нь Үндсэн хууль болон Хөрөнгө оруулалтын тухай хуулиараа гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих, гадаад дотоодын хөрөнгө оруулагчид тэгш эрхтэй байх зарчмыг хуульчилсан байна. Үндэсний аюулгүй байдалд харшлахгүй, хуулиар хориглоогүй бизнесийн салбарт гадаадын хөрөнгө оруулагч, аж ахуйн нэгжийг дэмжих бодлого барьдаг. Үндэсний болон стратегийн үйлдвэрлэлийг орлох, газар эзэмших, харилцаа холбоо, хэвлэл мэдээллийн болон уул уурхайн хайгуул, цөмийн энергийн зэрэг салбаруудад гадаадын хөрөнгө оруулалт (ГХО)-д тодорхой шалгуур тавьж, үндэсний аюулгүй байдлын хууль, дүрэм журмыг даган мөрдөнө.

Австрали Улс нь, хөрөнгө оруулалтынхаа эрх зүйн орчныг зургаан өөрчлөлтийн хүрээнд шинэчилжээ. Үүнд:

1. үндэсний аюулгүй байдлыг хамгаалах;
2. тогтвортой хөрөнгө оруулалтыг дэмжих;
3. хууль дүрмийг хэрэгжүүлж мөрдүүлэх, хариуцлагыг нэмэгдүүлэх;
4. хяналт үнэлгээний тогтолцооны нэгдмэл байдлыг хангах;
5. мэдээлэл цуглуулах, хуваалцах, солилцох үйл ажиллагааг хялбарчлах;
6. хөрөнгө оруулалтын доод хэмжээ тогтоох;
7. хураамжийн тогтолцоог боловсронгуй болгох (илүү шударга, хялбар байх).

Австрали Улсад ГХО-ыг дараах хууль тогтоомжуудаар зохицуулж байна.[2] Үүнд:

- Үндсэн хууль (Commonwealth of Australia Constitution Act);
- Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль (Foreign Acquisitions and Takeovers Act, 1975);
- Гадаадын хөрөнгө оруулалтын хураамжийн тухай хууль (Foreign Acquisitions and Takeovers Fees Impositions Act, 2015);
- Гадаадын хөрөнгө оруулалтын тухай журам (Foreign Acquisitions and Takeovers Regulation, 2015)[3].

Австрали Улсын Үндсэн хуулийн[4] 51 дүгээр зүйлд гадаад болон муж улсуудтай худалдаа хийх, татварыг алагчлалгүй тогтоох, бараа бүтээгдэхүүний экспортод урамшуулал тэгш олгохоор тусгасан байна.

Австрали Улс нь ГХО-ыг эдийн засгийнхаа салшгүй хэсэг гэж үзэх ба дотоодын хуримтлалыг ГХО-аар нэмэгдүүлдэг байна. Шинэ үйлдвэр барьж байгуулах, дэд бүтэц болон бүтээмжийг нэмэгдүүлэх, шинэ ажлын байр бий болгох замаар эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлдэг.

[2] https://foreigninvestment.gov.au/compliance/fi-laws
[3]https://www.cliffordchance.com/content/dam/cliffordchance/briefings/2017/08/foreign-investment-regulation-in-australia.pdf
[4] https://www.constituteproject.org/constitution/Australia_1985

### Хөрөнгө оруулагчид тавигдах нөхцөл, шаардлага

Австрали Улсын Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн дагуу үнэт цаас, хөрөнгө, Австралийн Улсад газар эзэмших, эсхүл тус улсын корпорац, хөрөнгө оруулалтын сан болон бусад бизнест хөрөнгө оруулах тохиолдолд **чухал ач холбогдол** бүхий үйл ажиллагаанд хамааруулдаг.[5] Дараах чухал ач холбогдол бүхий үйл ажиллагаа нь хөрөнгө оруулалтын доод хэмжээг давсан тохиолдолд холбогдох төрийн байгууллагад **мэдэгдвэл зохих үйл ажиллагаа** байдаг.[6] Үүнд:

- аж ахуйн нэгж (ААН) болон хөдөө аж ахуйн бизнест шууд хувь эзэмших;
- ААН-ийн хувьцааны дийлэнх хувь эзэмших;
- газар ашиглах, эзэмших.

Аливаа хөрөнгө оруулалтын үндэсний ашиг сонирхлын болон үндэсний аюулгүй байдлын сорилыг хийдэг.

Үндэсний ашиг сонирхлын сорилыг тодорхой хөрөнгө оруулалтын доод хэмжээ (monetary threshold)-г давсан хөрөнгө оруулалтад хийх ба **үндэсний ашиг сонирхлын сорилд** дараах хүчин зүйлсийг багтаана. Үүнд:

- үндэсний аюулгүй байдал;
- өрсөлдөөн;
- Австрали Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй бусад бодлого шийдвэрт нөлөөлөх нөлөө (тухайлбал, татварын орлого болон байгаль орчинд);
- эдийн засаг, нийгэмд үзүүлэх нөлөө;
- хөрөнгө оруулагчийн мэдээлэл.

Тодорхой хөрөнгө оруулалтын хэмжээг даваагүй хэр нь үндэсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй хөрөнгө оруулалтыг үндэсний аюулгүй байдлын сорилоор үнэлнэ.

### Хөрөнгө оруулалтын хэмжээ

Гадаадын хөрөнгө оруулагчдад хөрөнгө оруулалтын доод хэмжээг хувь хүн болон компани, мөн гадаад улсын төрийн өмчит компани гэсэн шалгууруар тогтоосон.[7] Гадаадын хөрөнгө оруулагчид бизнесийн төрөл, үйл ажиллагааны чиглэлээр хуулийн тодорхой шалгуурыг давсан тохиолдолд цахимаар хүсэлтээ гаргах боломжтой.[8] Хөрөнгө оруулалтын доод хэмжээ нь хөрөнгө оруулагч нь хэн болох, аль улсаас гаралтай зэрэг хүчин зүйлсээс хамаарах хэдий ч ихэнх хөрөнгө оруулагчдад тавигдах стандарт доод хэмжээ нь гадаадын хувийн хөрөнгө оруулагчдын Австрали Улс дахь хөгжингүй худалдааны нутаг дэвсгэрт хөрөнгө оруулахад тогтоосон 275 сая австрали доллар байдаг. Мөн газар эзэмших, ашиглахтай холбоотойгоор тухайн хөрөнгө оруулалтын дүнгийн хэмжээ өсдөг байна.

Тухайлбал, тус улсын хөдөө аж ахуйн салбарт хөрөнгө оруулах босго нь 15 сая австрали доллар байна. Хэрэв чөлөөт худалдааны гишүүн орны бизнес эрхлэгч бол хөрөнгө оруулалтын хэмжээний шалгууруас дээгүүр хөрөнгө оруулдаг.

### Газар эзэмших, ашиглах [9]

Австрали Улсад газрын харилцааг зохицуулах холбооны эрх зүйн зохицуулалт, тогтолцоо байхгүй, муж улсууд нь өөрийн хуулиар зохицуулдаг. Аборигэн болон Торресийн хоолойн арлын уугуул иргэд нь газрыг давуу эрхтэйгээр эзэмших, ашиглах, өмчлөх эрхтэй.

[5] https://foreigninvestment.gov.au/guidance/general/key-concepts#screening
[6] https://foreigninvestment.gov.au/guidance/general/key-concepts#screening
[7] https://foreigninvestment.gov.au/guidance/general/monetary-thresholds#_ftnref6
[8] https://www.ato.gov.au/online-services/foreign-investors/online-services-for-foreign-investors
[9] The monetary thresholds are outlined at www.foreigninvestment.gov.au.

Австрали Улсын Уугуул нутаг дэвсгэрийн тухай хуулиар (1994 онд батлагдсан[10]) уугуул иргэдийн газрын харилцааг зохицуулах, байгалийн баялаг, газрын үр шимийг тэгш хүртэх харилцааг зохицуулдаг.

Газрын доорх баялаг, ашигт малтмал, газрын тосны ордын нөөц ашиглах, олборлох эрх нь уугуул иргэдэд хамаарахгүй. Сул хоосон газар, агаар, ус, газрын гүний орон зай, улсын ой, цэцэрлэгт хүрээлэн, нийтийн хэрэгцээний газар болон бэлчээр, далайн эргийн наран шарлагын газар зэрэг нь төрийн буюу нийтийн өмч байна.[11]

Австрали Улсад газрыг гадаадын хөрөнгө оруулагчдад эзэмшүүлэх, ашиглуулах эрх зүйн боломж байдаг. Газрыг хөдөө аж ахуйн, уул уурхайн, үйлдвэрлэлийн болон орон сууцны зориулалттай газар гэж ангилдаг. Тодорхой хөрөнгө оруулалтын доод хэмжээ тавьж газрыг ашиглах, эзэмших эрхийн зөвшөөрлийг холбогдох төрийн байгууллагаас олгодог. Орон сууцны зориулалттай газрыг өмчлөх эрхийг тухайн орон сууцны хороололд оруулсан хөрөнгө оруулалт нь Австрали Улсад орон сууцны асуудлыг шийдвэрлэхэд хувь нэмэр оруулсан байх шаардлага тавина.

Гадаадын хөрөнгө оруулагчид тус улсад газар эзэмших, ашиглах тохиолдолд мөн тодорхой хуулийн шалгуур, хөрөнгө оруулалтын доод хэмжээ тавьсан байдаг.[12] Гадаадын хөрөнгө оруулагч иргэдэд тавих доод хэмжээ нь 330 саяас - 1 тэрбум 427 сая австрали доллар байна.

Гадаад улсын Засгийн газрын хөрөнгө оруулагчид газрын үнэ цэнээс үл хамаарч арилжааны зориулалттай газарт тусгай зөвшөөрөл авах ба аж ахуйн зориулалтаар ашиглах газрын хувьд тодорхой хугацаатай байна.

Гадаадын хөрөнгө оруулагчид уул уурхайн салбарт бизнес эрхлэх бол газар ашиглах, үл хөдлөх хөрөнгө барихын өмнө тусгай зөвшөөрөл авна. Чөлөөт худалдааны гэрээнд нэгдсэн улс орнуудын хөрөнгө оруулагчдын хувьд хөрөнгө оруулалтын доод хэмжээ, татвар, хөрөнгө эзэмших шалгуур өөр байдаг.[13] Хөрөнгө оруулагчийн хувьд уул уурхайн хайгуул, олборлолтын компанийн нийт хувьцааны 10 хувиас дээш хувьцаа эзэмшигч бол Сангийн яам, холбогдох байгууллагад заавал мэдэгдэх үүрэгтэй.

### Визийн хөнгөлөлт

Гадаадын хөрөнгө оруулагчдад түр болон байнга оршин суух буюу “алтан виз”-ийг санал болгодог. Мөн тэдний гэр бүлийн гишүүдэд нь түр оршин суух болон, олон удаа зорчих визний хөнгөлөлт үзүүлдэг. Тухайлбал:

- бизнесийн үйл ажиллагаагаа амжилттай явуулж байгаа, дор хаяж 750.000 австрали долларын хөрөнгийн эргэлттэй, 1.25 сая австрали долларын хөрөнгөө нотолсон бол тус улсад нэг жил оршин суух виз олгоно;
- Австрали Улсын удирддаг хөрөнгө оруулалтын санд 2.5 сая австрали долларыг түр визний хүчинтэй байх хугацаанд төлсөн бол оршин суух эрхийг 2 жилээр сунгана;
- эдийн засгийн тэргүүлэх салбарт хөрөнгө оруулалт хийсэн, эрдэм шинжилгээ судалгаа, инновац хөгжүүлэх дор дурдсан салбарт ажиллах мэргэжилтэнд байнга оршин суух виз олгоно:

[10] Уугуул нутаг дэвсгэрийн тухай хууль, Native Title Act 1994
[11] Австралийн Үндэсний газрын эрхтэй холбоотой тайлангууд. Native Title Reports (1994-2012) and Social Justice Reports (2013) on the Australian Human Rights Commission website for more information. A
[12] https://foreigninvestment.gov.au/sites/foreigninvestment.gov.au/files/2023-12/guidance-note-4-commercial-land-january-2024.pdf
[13] https://foreigninvestment.gov.au/sites/foreigninvestment.gov.au/files/2023-12/guidance-note-4-commercial-land-january-2024.pdf

- байгалийн нөөц, эрчим хүч, уул уурхайн технологи;
- хөдөө аж ахуйн технологи;
- батлан хамгаалах, сансар судлал, дэвшилтэт технологи;
- санхүүгийн үйлчилгээ ба технологи;
- эрүүл мэндийн салбар ба эмнэлгийн технологи;
- дэд бүтэц, аялал жуулчлал;
- боловсрол;
- кибер аюулгүй байдал;
- квантын мэдээлэл, дэвшилтэт дижитал технологи, мэдээллийн шинжлэх ухаан, мэдээлэл харилцаа холбооны технологи.

Австрали Улсын муж улсын Засгийн газраас 2 жил оршин суух эрхийг олгодог.

### Татварын хөнгөлөлт

Тус улсын Засгийн газар нь “Гадаад улсын Засгийн газрын хөрөнгө оруулагч” гэж ангилагдсан ААН-ийг тодорхой хөрөнгө оруулалтыг татвараас чөлөөлдөг. Энэ чөлөөлөлт нь гадаадын засгийн газрын хөрөнгө оруулагчид нь тухайн ААН-ийн хөрөнгө оруулалт, эсхүл үйл ажиллагааны шийдвэр болон ААН-ийн үндсэн хөрөнгөд нөлөөлөл, хяналт байхгүй тохиолдолд хэрэгжинэ.

## 2.ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛС

### Эрх зүйн орчин

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс (ХБНГУ) нь ГХО-аараа Европын холбооны төв болж байдаг. Учир нь тус улсын тогтвортой хууль, эрх зүйн орчин, ур чадвартай хүний нөөц, хөгжсөн дэд бүтцээрээ хөрөнгө оруулагчдыг байнга татаж байдаг бөгөөд ГХО-д либерал бодлого баримталдаг.

Тус улсад ГХО, түүнд тавих хяналтыг Гадаад худалдаа, төлбөр, тооцооны тухай хууль[14], Гадаад худалдаа, төлбөр, тооцооны журам[15] гэх гол хоёр хууль, тогтоомжоор зохицуулдаг. Энэхүү хууль, журмаар ХБНГУ-ын үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхлыг хамгаалах, олон нийтийн хэв журмыг хамгаалах, түүнчлэн, тус улсын төр, төрийн байгууллагуудын үйл ажиллагааг болон аюулгүй байдлыг хамгаалахад илүү чиглэсэн байна.

Харин ХБНГУ-д бизнес эрхлэх, оршин суух асуудлыг Холбооны нутаг дэвсгэрт гадаадын иргэн оршин суух, эдийн засгийн үйл ажиллагаа явуулах тухай хуулиар[16], мөн бизнесийн харилцааг дор дурдсан хуулиар зохицуулдаг. Үүнд:

- Иргэний хууль;
- Худалдааны хууль;
- Хязгаарлагдмал хувьцаат компанийн тухай болон хувьцаат компанийн тухай хууль;
- Шударга бус өрсөлдөөний тухай хууль.

### Хөрөнгө оруулагчид тавигдах нөхцөл, шаардлага

Гадаад улсаас ХБНГУ-д хувиараа бизнес эрхлэх (self-employment), хөрөнгө оруулалт хийх доод хэмжээг хуулиар тогтоогоогүй ч тухайн ААН-ийн хөрөнгө оруулалтын жишиг хэмжээ нь 360,000 евро байдаг бөгөөд дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

[14] Foreign Trade and Payments Act. https://www.gesetze-im-internet.de/englisch_awg/englisch_awg.html
[15] Foreign Trade and Payments Ordinance. https://www.gesetze-im-internet.de/englisch_awv/print_englisch_awv.html
[16] Act on Residence, Economic Activity and Integration of Foreigners in the Federal Territory. https://www.gesetze-im-internet.de/englisch_aufenthg/englisch_aufenthg.html

- тус улсад хийх бизнесийн зорилгоо тодорхойлсон байх, бизнесийн төлөвлөгөө гаргасан байх, эрсдэлийн үнэлгээ хийсэн байх;
- тухайн бизнес нь тус улсын эдийн засгийн сонирхолд нийцсэн байх, муж улсын хэрэгцээ шаардлагыг хангасан байх;
- тухай ААН-ийн ажилчдын тоо хамгийн багадаа 5 байх.

### Газар эзэмших, ашиглах

ХБНГУ нь өөрийн улсын иргэдэд хөдөө аж ахуйн чиглэлээр ашиглаж байгаа эд хөрөнгө, газар өмчлөх асуудалд тодорхой хязгаарлалтыг Иргэний хууль[17], Газар эзэмших тухай хуулиар[18] тавьдаг боловч гадаадын иргэн, хөрөнгө оруулагч тус улсад газар эзэмшихэд хатуу хязгаарлалт тавьдаггүй, харьцангуй нээлттэй бодлого баримталдаг байна.

### Визийн хөнгөлөлт

Гадаад улсаас ХБНГУ-д хувиараа бизнес эрхлэх (self-employment), аж ахуй нэгжийн үйл ажиллагаа явуулах зорилгоор виз мэдүүлснээр тус улсад оршин суух эрх олж авах, цаашлаад тус улсын иргэн болох эрх үүсдэг. Бусад улс оронтой харьцуулбал, оршин суух болон иргэн болоход тавигдах шаардлага, цаг хугацааны хувьд шуурхай байдаг. Өөрөөр хэлбэл, ХБНГУ-д хөрөнгө оруулалт хийх, хөрөнгө оруулалтын виз авснаас хойш 3 жилийн дараа байнгын оршин суух, 8 жилийн дараа ХБНГУ-ын иргэн болох эрхтэй.

Гадаад улсаас ХБНГУ-д хувиараа бизнес эрхлэх (self-employment), хөрөнгө оруулалт хийхээр виз мэдүүлэгч нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- 18 насанд хүрсэн байх;
- ял шийтгэл хүлээж байгаагүй;
- бизнесийн салбарт ажилласан туршлагатай байх;
- өөрийн хөрөнгө, эсхүл зээлийн амлалт (loan commitment) гаргаж хөрөнгө оруулалтын сангаа баталгаажуулсан байх.

Гадаад улсаас ХБНГУ-д хувиараа бизнес эрхэлж (self-employment), эсхүл хөрөнгө оруулалт хийснээр гэр бүлийн гишүүд тус улсад оршин суух виз мэдүүлэх эрхтэй. Гэр бүлийн гишүүн гэдэгт дараах хүмүүс хамаарна. Үүнд:

- эхнэр, нөхөр, эсхүл хамтран амьдрагч;
- 18-аас доош насны хүүхэд;
- эрүүл мэндийн болон санхүүгийн хувьд тухайн этгээдээс шууд хамааралтай насанд хүрсэн хүн.

### Татварын урамшуулал

ХБНГУ нь ААН-ийн татварын өрсөлдөөнт системийг санал болгодог бөгөөд холбооны хэмжээнд татварын дундаж ачаалал 30-аас доошгүй хувь байдаг.

ХБНГУ-д үйл ажиллагаа эрхэлж, ашиг хүртэж байгаа бүх ААН 15 хувийн орлогын албан татварыг төлөх үүрэгтэй. ААН-ийн орлогын албан татвар ногдуулахдаа дараах байдлаар төлөх ба энэ нь гадаадын хөрөнгө оруулагчдад үзүүлж байгаа татварын урамшууллын нэг хэлбэр юм:

- хязгаарлагдмал хариуцлагатай компани (GmbH) болон хувьцаат компанийн төв оффис, эсхүл гүйцэтгэх зөвлөл нь ХБНГУ-д байрладаг бөгөөд олон улсад үйл ажиллагаа эрхэлж олсон орлогоос ААН-ийн орлогын албан татварыг ХБНГУ-д төлнө. Харин

[17] German Civil Code https://www.gesetze-im-internet.de/englisch_bgb/englisch_bgb.html
[18] Grundbuchordnung https://www.gesetze-im-internet.de/englisch_bgb/englisch_bgb.html

тухайн ААН нь өөр улсад энэ төрлийн татвар төлсөн тохиолдолд ХБНГУ-д төлөхгүй, чөлөөлөгдөнө;

- хязгаарлагдмал хариуцлагатай компани (GmbH) болон хувьцаат компанийн төв оффис, эсхүл гүйцэтгэх зөвлөл нь ХБНГУ-д байрладаггүй бол тус улсын нутаг дэвсгэрт олсон орлогоос ААН-ийн орлогын албан татварыг төлнө.

## 3.КАНАД УЛС

### Эрх зүйн орчин

Канад Улсын хөрөнгө оруулалтын тухай хууль (Investment Canada Act)-ийн зорилго нь ГХО-ыг татах, улмаар эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх, шинэ технологийг нэвтрүүлэх, тус улсын иргэдэд ажлын байр бий болгоход оршино.

Энэ хуулийн хэрэгжилтийг Канад Улсын инновац, шинжлэх ухаан, эдийн засгийн хөгжлийн газар (Department of Innovation, Science and Economic Development Canada (ISED)) хариуцдаг. Мөн Захиргааны зөвлөл (Governor-in-Council (GiC)) нь үндэсний аюулгүй байдлыг хангах, хяналт шалгалт хийх байгууллагуудтай хамтран ажиллах, хуулийн хэрэгжилтийг хангах зэрэг чиг үүрэгтэй.[19] Харин соёлын салбартай холбоотой хөрөнгө оруулалтыг Канад Улсын өвийн газар хариуцдаг.[20]

Тус улсын Инновац, шинжлэх ухаан, эдийн засгийн хөгжлийн сайд нь үндэсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй хөрөнгө оруулалтыг Захиргааны зөвлөлөөр хяналт, шалгалт хийлгүүлнэ.[21] Захиргааны зөвлөлөөс Канад Улсын үндэсний аюулгүй байдалд хохирол учруулах магадлалтай гэж дүгнэлт гаргасан бол тухайн хөрөнгө оруулалтыг татгалзах, эсхүл заасан нөхцөл, болзлыг хэрэгжүүлэх шаардлагыг тавих эрхтэй.

Захиргааны зөвлөл нь үндэсний аюулгүй байдалтай холбоотой дараах хүчин зүйлсийг харгалзан үзнэ:

- Канад Улсын Батлан хамгаалах хүчин чадалд нөлөө үзүүлэх эсэх;
- хөрөнгө оруулалт нь одоо болон ирээдүйд хууль сахиулах үйл ажиллагаанд саад учруулах эсэх;
- зохион байгуулалттай гэмт хэрэг, авлигын хэрэгт холбогдсон гадаадын албан тушаалтнууд зэрэг этгээдүүд оролцсон эсэх;
- хувь хүний дараах нууц мэдээлэл агуулсан эсэх -
    a) эрүүл мэндийн болон генетикийн шинжилгээний үр дүн;
    b) биометрийн мэдээлэл (хурууны хээ);
    c) санхүүгийн мэдээлэл;
    d) газарзүйн байршил;
    e) төрийн албан тушаалтнууд, түүний дотор цэрэг, тагнуулын ажилтнуудын мэдээлэл зэргийг агуулсан хөрөнгө оруулалт нь Канад Улсын үндэсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх магадлалтай гэж үздэг байна.[22]

[19] Канад Улсын хөрөнгө оруулалтын тухай хуулийн 35-р зүйл.
[20] https://ised-isde.canada.ca/site/investment-canada-act/en/what-investment-canada-act
[21] https://ised-isde.canada.ca/site/investment-canada-act/en/investment-canada-act/guidelines/guidelines-national-security-review-investments
[22] https://ised-isde.canada.ca/site/investment-canada-act/en/investment-canada-act/guidelines/guidelines-national-security-review-investments 8

## Гадаадын хөрөнгө оруулагчид тавигдах нөхцөл, шаардлага

Канад Улс нь гадаадын хөрөнгө оруулагч нарт таатай нөхцөлийг бүрдүүлэхийн тулд олон төрлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг санал болгодог. Тухайлбал, хөрөнгө оруулалтын цагаачлалын хөтөлбөр нь холбооны болон мужийн гэж ангилах бөгөөд эдгээр хөтөлбөр нь хөрөнгө оруулалтыг татахад чухал үүрэг гүйцэтгэдэг.

**Хүснэгт 2. Холбооны болон мужийн хөрөнгө оруулалтын цагаачлалын хөтөлбөрийн харьцуулалт[23]**

| | **Холбооны цагаачлалын хөтөлбөрөөр хөрөнгө оруулах** | **Мужийн цагаачлалын хөтөлбөрөөр хөрөнгө оруулах** |
|---|---|---|
| Хөрөнгө оруулалтын хэмжээ | 250,000-350,000 канад доллар | 100,000-350,000 канад доллар<br>Бизнесийн онцлогоос шалтгаалаад үнийн дүн бага байж болно. |
| Материал бүрдүүлэх хугацаа | 1-3 сар | 6-8 сар |
| Байнгын оршин суух хугацаа | 2+ жил | 2+ жил |
| Хэрэгжих хөтөлбөрүүдийн нэр | • Канадад үйл ажиллагаа өргөжүүлэх зорилготой хөрөнгө оруулагч нарт зориулсан хөтөлбөр (Intra-Company Transfer (ICT))<br>• Гарааны бизнес эрхлэгч нарт зориулсан хөтөлбөр (Start-Up Visa Program (SUV))<br>• Бизнест хөрөнгө оруулах, эсхүл шинэ бизнес эхлүүлэх хүмүүст зориулсан хөтөлбөр (Entrepreneur Visa (C11))<br>• Бизнес эрхлэгч, хөрөнгө оруулагч нарт ажиллах эрх олгох, улмаар байнгын оршин суух эрх олгох хөтөлбөр (LMIA Work Permit Program) | Канад Улсын муж бүрээс бизнесийн цагаачлалын хөтөлбөрийг өөрийн онцлогт тохируулж санал болгодог. Хөтөлбөр тус бүрд хөрөнгө оруулалтын хэмжээ, тавигдах шаардлага, хөрөнгө оруулалтын чиглэл зэргийг нарийн тусгаж өгдөг. |

Харин хөрөнгө оруулагчдад дараах шаардлагыг тавьдаг:

- анхны хөрөнгө оруулалтыг хэмжээ 100,000-аас 350,000 канад долларын (CAD) хооронд хэлбэлзэнэ. Хувийн болон санхүүгийн чадамжаас хамааран дээрх дүнгээс өндөр, эсхүл бизнес төлөвлөгөө, зах зээлд нэвтрэх стратеги, бизнесийн онцлогоос хамааран бага байж болно[24];
- нарийвчилсан бизнес төлөвлөгөөтэй байх;
- бизнесийн туршлага, ур чадвартай байх;
- Канад Улсад бизнес эрхлэх чин хүсэлтэй байх;
- хөрөнгө оруулагчдад виз олгох цагаачлалын хөтөлбөрийн шалгуурыг хангасан байх зэрэг шаардлагыг тавьдаг байна.

Тус улсад хөрөнгө оруулагч болох дараах 4 арга байдаг:

[23] https://sobirovs.com/canada-investor-visa-learn-about-investment-immigration/
[24] https://sobirovs.com/business-immigration/business-owner-citizenship/

- шинэ бизнес эхлүүлэх;
- бизнес худалдаж авах;
- идэвхтэй бизнесийн хувьцаа эзэмшигч болох (33 хувь ба түүнээс дээш);
- франчайз эрх худалдах авах.

**Хүснэгт 3. Хөрөнгө оруулалтад тавигдах шаардлага, нөхцөл**

| Хөрөнгө оруулалтын төрөл | Хөрөнгө оруулалтын үнэ | Эрсдэл | Оршин суух өргөдөл бүрдүүлэх хугацаа | Байнгын оршин суух өргөдөл гаргах нөхцөл |
|---|---|---|---|---|
| Шинэ бизнес эхлүүлэх | $50,000+ | Өндөр | Хамгийн багадаа 12 сар | 12 сар Үйл ажиллагаа идэвхтэй явуулсан байх<br>Оффистой байх<br>Хамгийн багадаа 1 Канад ажилтантай |
| Бизнес худалдаж авах | $50,000-$250,000+ | Дунд | Тодорхойгүй | Хувьцааны 51 хувийг эзэмших<br>Хамгийн багадаа 1 Канад ажилтантай |
| Идэвхтэй бизнесийн хувьцаа эзэмшигч болох | $200,000-$300,000 | Дунд | Тодорхойгүй | Компани нь дор хаяж 12 сар оршин тогтносон<br>Үйл ажиллагаа явуулах хангалттай хөрөнгөтэй байх |
| Франчайз эрх худалдах авах | $100,000+ | Бага | Тодорхойгүй | Үйл ажиллагаа тогтвортой<br>Хамгийн багадаа 1 Канад ажилтантай |

## Газар эзэмших, ашиглах

Канад Улсын газар эзэмших, ашиглах холбоотой асуудлыг Газар өмчлөлийн тухай журмаар зохицуулдаг байна. Энэхүү журамд зааснаар тус улсын Газар өмчлөлийн алба нь гадаадын хөрөнгө оруулагчид газар эзэмшихтэй холбоотой асуудлуудыг хариуцдаг.

Канад Улс нь гадаадын хөрөнгө оруулагчид тус улсын нутаг дэвсгэрийг 20 хүртэлх жилийн хугацаатай түрээслүүлэх бөгөөд түрээсийн гэрээ байгуулагдсанаас хойш 60 хоногийн дотор газар өмчлөх албанд хүсэлт гарган түрээсийн гэрээгээр хугацааг дахин сунгах боломжтой. Мөн гадаадын хөрөнгө оруулагчдад 20 хүртэлх акр (acre) хэмжээтэй 2 хүртэлх газрыг түрээслүүлнэ.[25]

## Визийн хөнгөлөлт

Холбооны болон мужийн хөрөнгө оруулалтын цагаачлалын хөтөлбөрөөр дамжуулан байнгын оршин суух, иргэншил авах боломжийг гадаадын хөрөнгө оруулагч болон түүний гэр бүлд олгодог байна.

Хөрөнгө оруулагчид байнгын оршин суух эрхтэй 3 жил амьдарсны дараагаар иргэншил авах боломж бүрддэг. Иргэншил хүсэгч нь англи, эсхүл франц хэлний мэдлэгтэй байх бөгөөд гэмт хэргийн бүртгэлгүй байх шаардлагатай. Мөн Канад Улсын цагаачлалын хуульд зааснаар гадаадын хөрөнгө оруулагчид үл хөдлөх хөрөнгө худалдан авсан тохиолдолд иргэншил

[25] https://kings-printer.alberta.ca/

олгодоггүй. Харин байнгын оршин суух болон бизнес эхлүүлэхэд дэмжлэг болох байдлаар нөлөөлдөг байна.[26]

Канад Улсад хөрөнгө оруулах, бизнес эрхлэгчээр ажиллах зөвшөөрлийг ойролцоогоор 2-4 сар, байнгын оршин суух зөвшөөрлийг 1-2 жил шаардагдана гэж тодорхойлсон байдаг. Эдгээр хугацаа нь өргөдөл гаргагчийн газарзүйн байршил, өргөдлийн төрөл бизнесийн гүйцэтгэл, бусад баримт бичгээс шалтгаалан дээрх тодорхойлсон хугацаанд өөрчлөлт орох магадлалтай байна.

### Хөрөнгө оруулагчид олгох бусад төрлийн урамшуулал

Канад Улсын байнгын оршин суух эрх, иргэншил авсан иргэдэд олон давуу талтай бөгөөд Канад Улсын иргэншил нь эцсийн дүндээ хүчтэй паспортыг санал болгож байдаг. Учир нь дэлхийн 197 орон руу чөлөөтэй зорьчих эрхтэй байдаг нь хамгийн том давуу тал болдог.

Байнгын оршин суугч болон иргэншилтэй иргэдэд үнэ төлбөргүй эрүүл мэндийн тусламж үйлчилгээний системтэй.

Канад Улсын эдийн засаг нь өндөр хөгжсөн орны хувьд тус улсад үйл ажиллагаагаа өргөжүүлэхээр зорьж буй хөрөнгө оруулагчдад татварын дараах хөнгөлөлтийг үзүүлдэг. Жишээлбэл:

- судалгаа, хөгжүүлэлтийн үйл ажиллагаа эрхэлдэг компаниудыг 15 хувийн буцаан олгогдохгүй татварын хөнгөлөлт эдэлнэ;
- хорт бодис ялгаруулдаггүй технологи үйлдвэрлэгчдийн татварын хэмжээг 50 хувиар бууруулна;
- 2022 оны төсөвт тус улсад утааны бохирдлыг бууруулах зорилгодоо хүрэхийн тулд утааг бууруулах технологи, зай хураагуурын шинэлэг шийдэл зэрэг хөрөнгө оруулалтад 30 хүртэлх хувийн татварын хөнгөлөлт үзүүлнэ.[27]

## 4.БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС

Бүгд Найрамдах Солонгос Улс (БНСУ) нь ойролцоогоор 1.6 их наяд америк доллар (ам.доллар)-ын эдийн засагтай дэлхийн 10 дахь том эдийн засагтай улс юм. 2022 оны байдлаар тус улсын худалдааны хэмжээ дэлхийд 6 дугаар байранд, 2023 оны 2 дугаар сарын байдлаар гадаадын валютын нөөцөөрөө дэлхийд 9 дүгээр байранд орж байна.

Тус улсын ГХО нь Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих тухай хуульд заасан ГХО-ын бүс, Чөлөөт худалдааны бүсийг тогтоох, удирдах тухай хуульд заасны дагуу худалдааны чөлөөт бүс болон Удирдлага, зохицуулалтын тухай тусгай хууль (Special Act on Designation and Management)-д заасны Хөрөнгө оруулалтын төрлөөс хамаарч ГХО-д тавигдах шаардлага, бизнесийн төрөл, хөнгөлөлт (түрээсийн төлбөр, татвар, гааль, бэлэн мөнгө) өөр өөр байдаг. Одоогийн байдлаар ГХО-ын 110 бүс, Кёнги аймгийн ГХО-ын 4 бүс, худалдааны чөлөөт 13 бүс, эдийн засгийн чөлөөт бүс 9 байна.

Энэхүү судалгаанд Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих тухай хуульд заасан ГХО-ын бүсийн талаарх зохицуулалтыг авч үзсэн болно.

[26] https://sobirovs.com/canada-investor-visa-learn-about-investment-immigration/
[27] https://www.investcanada.ca/news/canadas-corporate-tax-system-explained

### Эрх зүйн орчин

БНСУ нь гадаадын хөрөнгө оруулалтыг бие даасан хуулиар зохицуулдаг бөгөөд гадаадын хөрөнгө оруулалттай холбоотой үндсэн асуудлыг дараах хууль тогтоомжоор зохицуулж байна. Үүнд:

- Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих тухай хууль (Foreign Investment Promotion Act);
- Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих тухай хуулийг хэрэгжүүлэх тухай тогтоол, журам;
- Гадаадын хөрөнгө оруулалтын тухай журам (Худалдаа, үйлдвэр, эрчим хүчний яам);
- Гадаадын хөрөнгө оруулалтын нэгдсэн мэдэгдэл (Худалдаа, үйлдвэр, эрчим хүчний яам);
- Гадаадын хөрөнгө оруулалтын татварөөс чөлөөлөх журам (Стратеги, сангийн яам);
- Тусгай татварын тухай хуулийг хязгаарлах тухай (Гадаадын хөрөнгө оруулалтад ногдуулах тусгай албан татвар), хуулийн хэрэгжилтийг хангах тухай тогтоол, журам;
- Гадаад валютын гүйлгээний тухай хууль;
- Чөлөөт худалдааны бүсийг тогтоох, удирдах тухай хууль;
- Санхүүгийн хөрөнгө оруулалтын үйлчилгээ, хөрөнгийн зах зээлийн тухай хууль.

Дээр дурдсан хууль тогтоомжоос гадна үйлдвэр байгуулах, газар ашиглах, байгаль орчин болон татвартай холбоотой асуудлыг салбарын хууль тогтоомжоор зохицуулдаг. Тухайлбал, Татварын дэмжлэг үзүүлэхтэй холбоотой харилцаг Тусгай татварын хязгаарлалтын тухай хууль (Restriction of Special Taxation Act), орон нутгийн тусгай татварын хязгаарлалтын тухай хууль (Restriction of Special Local Taxation Act)-иар зохицуулдаг.

### Гадаадын хөрөнгө оруулагчид тавигдах нөхцөл, шаардлага

Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих тухай хуулийн 4 дүгээр зүйлд БНСУ-ын хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол гадаадын иргэн БНСУ-д ямар ч хязгаарлалтгүйгээр ГХО-тай төрөл бүрийн үйл ажиллагаа явуулж болно гэж заасан. Гадаадын шууд хөрөнгө оруулалт гэж хөрөнгө оруулалтын хэмжээ 100 сая вон ба түүнээс дээш, ГХО-ын харьцаа 10 хувь ба түүнээс дээш бол гадаадын иргэн БНСУ-д тусгай зохицуулалтаас бусад тохиолдолд хязгаарлалтгүй бизнес эрхлэх боломжтой.

Хөрөнгө оруулалтын төрөлд дотоодын компанийн хувьцааг худалдан авах, гадаад дахь толгой компаниас 5 ба түүнээс дээш жилийн хугацаатай урт хугацаатай зээл авах, шинжлэх ухаан, технологийн чиглэлээр ашгийн бус корпорацуудад хөрөнгө оруулах зэрэг багтана. Тодруулбал, Хувьцаа худалдан авах гэж ГХО-ын хэмжээ нь 100 сая ба түүнээс дээш вон бөгөөд дотоодын корпорац, компанийн гаргасан саналын эрхтэй хувьцааны 10-аас дээш хувийг эзэмшдэг, эсхүл нийт хувьцааны 10-аас доош эзэмшдэг боловч корпорац, компанийн гүйцэтгэх удирдлагад томилогдсон тохиолдлыг хэлнэ.

Түүнчлэн ГХО-тай компани үйлдвэрээ барих, өргөтгөхөд зориулагдаагүй хуримтлагдсан ашгаа ашигласан тохиолдолд гадаадын хөрөнгө оруулалт гэж үзнэ.

### Гадаадын хөрөнгө оруулалтад тавигдах хязгаарлалт

Тус улсад гадаадын шууд хөрөнгө оруулалтыг хязгаарласан хязгаарлалт байхгүй ч зарим салбарт ГХО-ыг тодорхой хувиар хязгаарласан хязгаарлалтууд байдаг. Тухайлбал, Махны чиглэлийн үхэр, махны бөөний худалдаа, эрчим хүч дамжуулах, түгээх, цахилгаан эрчим хүчний борлуулалт, дотоодын боомт, агаарын зорчигч/ачааны тээвэр, сонин хэвлэл, сэтгүүл, тогтмол хэвлэл зэрэгт ГХО 50 хүртэл хувь, усан цахилгаан станц, дулааны эрчим хүч, нарны эрчим хүч болон бусад эрчим хүч үйлдвэрлэх үйлдвэрүүдийн нийт дотоодын эрчим хүч үйлдвэрлэх байгууламжийн 30 хүртэл хувьд ГХО оруулахыг зөвшөөрдөг. Харин цөмийн эрчим

хүч үйлдвэрлэх, радио өргөн нэвтрүүлэг болон хуурай газрын өргөн нэвтрүүлэгт ГХО оруулахыг хориглосон байна.

### Визийн хөнгөлөлт

Гадаадын хөрөнгө оруулагчдад зориулсан оршин суух D-8 визийг олгодог. Тус визийг Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих тухай хуульд заасан шаардлага хангасан ГХО-тай компанийн удирдлага, үйлдвэрлэл, технологи болон техникийн өндөр ур чадвартай мэргэжилтнүүд, үйлдвэрлэлийн болон оюуны өмчийн эрх эзэмшигчдэд олгодог.

Виз нь хуулийн этгээд (D8-1), венчур компани (D8-2), хувь компанид хөрөнгө оруулагч (D8-3), технологи нэвтрүүлэгч (D8-4) гэсэн төрлүүдтэй.

Хөрөнгө оруулагчийн D-8 визтэй гадаадын иргэдийг дагалдан яваа гэр бүлийн гишүүд хөрөнгө оруулагчийн виз, оршин суух хугацаатай ижил байна.

### Газар эзэмших, ашиглах

БНСУ-д гадаадын хөрөнгө оруулагчид тус улсын иргэдтэй адил ялгаварлалгүйгээр үл хөдлөх хөрөнгө худалдан авч болно.

Цогцолбор хэлбэрийн ГХО-ын бүс нь зөвхөн гадаадын хөрөнгө оруулагч компаниудад тусгайлан түрээслэх, шилжүүлэхэд зориулагдсан бүс юм. Түрээсийн хугацаа 50 жил байх ба 10 жил тутамд сунгах гэрээ байгуулах ёстой. Энэ бүс рүү шилжиж буй компаниудад хөрөнгө оруулалтаас хамааран түрээсийн хөнгөлөлт, татварын хөнгөлөлт үзүүлдэг.

### Хөрөнгө оруулалтад олгох урамшуулал, дэмжлэг

Тус улс гадаадын хөрөнгө оруулагчдад татварын болон түрээсийн хөнгөлөлт, байршлын дэмжлэг болон санхүүгийн дэмжлэг үзүүлдэг.

**Байршлын дэмжлэгт** ГХО-ын бүс нь цогцолбор (Complex type Foreign Investment Zone), бие даасан (Individual type Foreign Investment Zone) болон үйлчилгээний (Service type Foreign Investment Zone) төрлийн ГХО-ын бүс гэж хуваадаг. Цогцолбор болон бие даасан ГХО-ын бүс нь түрээсийн төлбөр бага, тодорхой шаардлагыг хангасан тохиолдолд түрээсийн нэмэлт хөнгөлөлт, татвараас чөлөөлөх боломжтой. Үйлчилгээний төрлийн ГХО-ын бүсүүд татварыг бууруулахад дэмжлэг үзүүлэхгүй боловч түрээс, татаас зэрэгт давуу талтай.

**Санхүүгийн дэмжлэгт** Тусгай татварын тухай хууль, Аж үйлдвэрийн хөгжлийн тухай хууль Материал, эд анги, тоног төхөөрөмжийн үйлдвэрлэлийн өрсөлдөх чадварыг бэхжүүлэх тусгай арга хэмжээний тухай хууль, ГХО-ыг дэмжих тухай хууль болон Тусгай татварын хязгаарлалтын тухай хуульд заасан зорилтуудыг хангахад чиглэсэн арга хэмжээг дэмжиж төрөөс олгох санхүүгийн дэмжлэг юм. Санхүүгийн дэмжлэг үзүүлэх эсэхийг Стратеги, сангийн сайд болон холбогдох орон нутгийн засаг захиргаатай зөвшилцсөний үндсэн дээр Гадаадын хөрөнгө оруулалтын хороогоор хэлэлцэн шийдвэрлэсний үндсэн дээр Худалдаа, үйлдвэрлэл, эрчим хүчний яам тогтоож, санхүүгийн дэмжлэг үзүүлэх гэрээ байгуулснаар олгодог.

**Хүснэгт 4. Гадаадын хөрөнгө оруулалтын бүсэд үзүүлэх хөнгөлөлт, чөлөөлөлт**

| Ангилал | | Цогцолбор хэлбэрийн ГХО-ын бүс | Бие даасан хэлбэрийн ГХО-ын бүс |
|---|---|---|---|
| **Байршил** | | Аж үйлдвэрийн цогцолборууд | Хөрөнгө оруулагчдын сонголт бөгөөл хязгаарлалт байхгүй. |
| **Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт** | **Хөнгөлөлт, чөлөөлөлтөд тавигдах шаардлага** | -Үйлдвэрлэл: доод тал нь 10 сая ам.доллар<br>-Логистик: доод тал нь 5 сая ам.доллар | |
| | **Орон нутгийн татвар** | Орон нутгийн засаг захиргаанаас гаргасан шийдвэрийн дагуу 15 хүртэл жил чөлөөлөгдөнө. | Орон нутгийн засаг захиргаанаас гаргасан шийдвэрийн дагуу 15 хүртэл жил чөлөөлнө. |
| | **Тариф** | Хөрөнгийн бараа импортолсон өдрөөс хойш 5 жил чөлөөлнө. | Хөрөнгийн бараа импортолсон өдрөөс хойш 5 жил чөлөөлнө. |
| | **НӨАТ** | Үгүй | Хөрөнгийн бараа импортолсон өдрөөс хойш 5 жил чөлөөлнө. |
| **Түрээсийн төлбөрийн хөнгөлөлт, чөлөөлөлт** | | • 1 сая ам.долларааc дээш үнийн дүнтэй шинэ өсөлтийн хөдөлгүүрийн үйлдвэрлэлийн технологи: 10 жилийн хугацаанд 100 хувь чөлөөлнө.<br>• 5 сая ам.долларааc дээш үнэтэй үйлдвэрлэлийн бизнес эрхлэгч: 75 хувь (100 хувь материал, эд ангиудын тусгай цогцолбор дотор) хөнгөлөлт үзүүлнэ.<br>• 200 ба түүнээс дээш бүтэн цагийн ажилтантай 2.5 сая ам.доллар ба түүнээс дээш үнэтэй боловсруулах үйлдвэр: 100 хувь чөлөөлнө.<br>• 150 ба түүнээс дээш бүтэн цагийн ажилтантай 2.5 сая ам.доллар ба түүнээс дээш үнэтэй боловсруулах үйлдвэр: 90 хувь хөнгөлнө.<br>• 70 ба түүнээс дээш бүтэн цагийн ажилтантай 2.5 сая ам.доллар ба түүнээс дээш үнэтэй боловсруулах үйлдвэр: 75 хувь хөнгөлнө. | Зориулалтын болон түрээсийн хувьд 100 хувь чөлөөлнө. |

## 5. НИДЕРЛАНДЫН ХААНТ УЛС

### Эрх зүйн орчин

Нидерландын Хаант Улс (Нидерланд Улс)-д Хөрөнгө оруулалт, хуулийн этгээдийн нэгдэл, худалдан авалтын тухай хууль (Vifo Act)-аар үндэсний аюулгүй байдалд эрсдэл учруулж болзошгүй ГХО, хуулийн этгээдийн нэгдэл, хуулийн этгээлийн ногдол хувь, хувьцааг худалдан авалтын аюулгүй байдлын хяналт шалгалтыг нэвтрүүлсэн. Мөн гадаадын хөрөнгө оруулагчдыг дэмжих хөтөлөр (Wealthy Foreigners Scheme) хэрэгжүүл хэрэгжүүлж байсан. Энэ хөтөлбөр нь 2024 оны 1-р сарын 1-ний байдлаар дуусгавар болсон.

### Гадаадын хөрөнгө оруулагчид тавигдах нөхцөл, шаардлага

Нидерланд Улсад оршин суух зөвшөөрөл авахад дараах ерөнхий нөхцөлүүдийг тавьдаг:

- хүчинтэй паспорттой байх;
- нийтийн хэв журам, үндэсний аюулгүй байдалд эрсдэл учруулахгүй байх;
- Нидерланд Улсад ирээд сүрьеэгийн шинжилгээ өгөхөд бэлэн байх.

Гадаадын хөрөнгө оруулагчдад зориулсан тусгай нөхцөлүүд:

- хамгийн багадаа 1,250,000 еврогийн хөрөнгө оруулалт хийнэ. Хөрөнгө оруулалтыг дараах байдлаар хийж болно:
  - Нидерланд Улсад байрладаг компанид шууд хөрөнгө оруулах.
  - Эдийн засгийн яамнаас SEED хөтөлбөрт нийцнэ гэж үзэх фонд байгуулах. (Хөдөө аж ахуй, хүнс; өндөр технологи; эрүүл мэнд; эрчим хүч; тээвэрлэлт; болон мэдээллийн технологийн салбар дахь гарааны бизнесүүд SEED хөтөлбөрт хамрагдах боломжтой. Энэхүү хөтөлбөр нь санхүүгийн дэмжлэгээс гадна зөвлөгөө, холбоо харилцаа тогтоох гэх мэт бодит дэмжлэгээс бүрдэнэ.)
  - гарааны хөрөнгийн (*Venture Capital*) компани үүсгэх.
  - Нидерланд Улсад байрлах компанид гэрээт хамтарсан хөрөнгө оруулалт хийх.

  Хувийн хэрэглээний үл хөдлөх хөрөнгө энэ бодлогод үл хамаарна.
- Нидерланд Улсын, эсхүл Нидерланд Улсад салбартай Европын Холбооны гишүүн улсын банкны дансанд хөрөнгө оруулах мөнгөө байршуулах;
- хөрөнгө оруулсан хөрөнгийг хууль бус аргаар олж авааагүй байх;
- оршин суух зөвшөөрөл хүссэн өргөдөлдөө буруу мэдээлэл өгөөгүй, холбогдох мэдээллийг нуугаагүй байх;
- Өмнө нь Нидерланд Улсад хууль бусаар амьдарч байгаагүй байх.

Оруулсан хөрөнгө оруулалт нь Нидерланд Улсын эдийн засагт нэмүү өртөгтэй. Хөрөнгө оруулалт нь дараах 3 шалгуурын 2-ыг хангасан тохиолдолд нэмүү өртөгтэй гэж үзнэ:

1. 5 жилийн дотор 10-аас доошгүй ажлын байр бий болгох;
2. Нидерланд Улсын компанийн шинэлэг байдлыг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулсан байх. Үүнийг патент нэвтрүүлэх, технологийн болон технологийн бус шинэлэг зүйлд хөрөнгө оруулалт хийх, эсхүл шилдэг салбарт хамаарах компанид хөрөнгө оруулах зэргээр нотолж болно;
3. тодорхой мэдлэг, сүлжээ, үйлчлүүлэгчид, хөрөнгө оруулагчийн идэвхтэй оролцоо гэх мэт өөр нэг санхүүгийн бус нэмүү өртөгтэй байх.

### Визийн хөнгөлөлт

Энэ хөтөлбөр нь 3 жилийн хугацаатай, ажиллах эрхтэй түр оршин суух зөвшөөрлийг гадаадын хөрөнгө оруулагч болон гадаадын хөрөнгө оруулагчийн гэр бүлийн гишүүдэд олгоно. Нидерланд Улсад байр түрээсэлсэн, эсхүл худалдаж авсан; Нидерланд Улсын эрүүл мэндийн даатгалд хамрагдсан; орон нутгийн татвараа төлсөн; гэмт хэрэгт холбогдоогүй тохиолдолд зөвшөөрлийг 2 жилээр сунгаж болно. Сунгасан тухайд нэг хүний 1200 евро төлнө. Энэ зөвшөөрөл нь Нидерланд Улсад хамгийн багадаа хуанлийн 1 жилийн 4 сар байхыг шаардана. Үүнийг олон үе болгон хуваж болно (2 удаа 2 сараар гэх мэт).

Энэ хөтөлбөрөөр Нидерланд Улсад 5 жил амьдарсан бол гадаадын хөрөнгө оруулагч болон гадаадын хөрөнгө оруулагчийн гэр бүлийн гишүүд Нидерланд Улсын байнгын оршин суугч болох, эсхүл Нидерланд Улсын пасспорт авах боломжтой. Аливаа тохиолдолд хэл, соёл, болон хөдөлмөрийн зах зээлийн талаарх шалгалт өгөх ёстой.

Байнгын оршин суух зөвшөөрөл, эсхүл Нидерланд Улсын паспорт авсны дараа хөрөнгө оруулалтаа идэвхтэй байлгах шаардлагагүй. Байнгын оршин суугч нь үндэсний сонгуульд санал өгөх боломжгүй боловч орон нутгийн сонгуульд саналаа өгч болно. Байнгын оршин суугч гадаадад дээд тал нь 4 сар дараалан байж болно. Үүний дараа Нидерланд Улсад тодорхой хугацаагаар байх шаардлагатай (хамгийн багадаа 1 өдөр). Паспорттой бол Нидерланд Улсад оршин суух хугацааны шаардлага байхгүй.

### Газар эзэмших, ашиглах

Гадаадын иргэдэд Нидерланд Улсад үл хөдлөх хөрөнгө худалдаж авах ямарваа нэгэн хязгаарлалт байхгүй.

### Хөрөнгө оруулагчид олгох бусад төрлийн урамшуулал

Энэ хөтөлбөрт хамрагдсанаар гадаадын хөрөнгө оруулагч болон гадаадын хөрөнгө оруулагчийн гэр бүлийн гишүүд нь Европын Холбооны орнуудад визгүй зорчих эрхтэй болно. Цаашилбал, Нидерланд Улсын паспорттой болсноор дэлхийн 125 оронд визгүй зорчих эрхтэй болдог.

## 6. НОРВЕГИЙН ХААНТ УЛС

### Эрх зүйн орчин

Норвегийн Хаант Улс (Норвег Улс)-д хөрөнгө оруулалтын, түүн дотроо ГХО-ын бие даасан, тусгай хууль байдаггүй. Гэвч Үндэсний аюулгүй байдлын тухай хууль (The National Security Act, 2018)[28]-ийн “Өмчлөлийн хяналт” хэмээх 10 дугаар бүлэг, Өрсөлдөөний тухай хууль (The Competition Act, 2004) [29] болон бусад холбогдох дүрэм, журмаар хөрөнгө оруулалтын харилцааг зохицуулдаг.

Тус улсын хууль тогтоомжоор гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг ялгадаггүй бөгөөд хөрөнгө оруулалтад зарим нэг хязгаарлалт тогтоосон байдаг боловч тэдгээр нь гадаадын шууд хөрөнгө оруулагч нарт тусгайлан чиглэдэггүйгээрээ онцлогтой байна.

### Хөрөнгө оруулагчид тавигдах нөхцөл, шаардлага

Ерөнхийдөө Норвег Улсын хөрөнгө оруулалтын дэглэм нь гадаадын болон дотоодын хөрөнгө оруулагчдад адил тэгш хандах зарчимд суурилдаг, нээлттэй, чөлөөт (liberal) тогтолцоотой тул ГХО-д тусгай зөвшөөрөл шаарддаггүй.[30]

### Хөрөнгө оруулалтын хязгаарлалт

Норвег Улсад ГХО-д шууд чиглэсэн хязгаарлалт байхгүй боловч гадаад, дотоодын харьяалал харгалзахгүйгээр тодорхой салбарын хөрөнгө оруулалтад ерөнхий хязгаарлалт буюу концессын шаардлага тавьдаг. Цаашлаад үндэсний аюулгүй байдлын эрх ашиг, өрсөлдөөний хуулийн зохицуулалтаас шалтгаалсан нарийвчилсан хязгаарлалтууд ч бий.

[28] https://lovdata.no/dokument/NLE/lov/2018-06-01-24/KAPITTEL_10#KAPITTEL_10
[29] https://konkurransetilsynet.no/legislation/?lang=en
[30] https://www.globallegalpost.com/lawoverborders/the-new-world-of-foreign-direct-investment-246697424/norway-1134233103

Тэдгээр хязгаарлалтууд нь дараах салбаруудад үйлчилдэг байна[31]. Үүнд:

- хүрхрээ, ус, эрчим хүчний хангамж, уурхай;
- газар, үл хөдлөх хөрөнгө, урт хугацааны түрээс;
- тариалангийн газар, ой мод;
- санхүүгийн байгууллагууд;
- Засгийн газраас тусгай зөвшөөрөл олгогдсон эрдэс хайгуул, газрын тосны олборлолт, үйлдвэрлэл, худалдаа, загас агнуур, загасны аж ахуй.

Тэдгээр хязгаарлалтын зарим онцлох зохицуулалтаас дурдвал[32]:

- Тус улсын Үндэсний аюулгүй байдлын тухай хуулиар хэрэв тухайн хөрөнгө оруулалт нь Норвег Улсын үндэсний аюулгүй байдалд хамааралтай гэж үзвэл тус улсын компаниуд болон эсхүл, тэдгээрийн бизнесийн эд хөрөнгө, хувьцаа, ногдол хувийг эзэмших, өмчлөх асуудалд эрх бүхий байгууллагууд хөндлөнгөөс оролцох эрхтэй болсон. Тус хууль нь үндэсний аюулгүй байдалд заналхийлж буй аливаа эрсдэл, үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх, тэдгээрийг илрүүлэх, арилгах, эсэргүүцэх аюулгүй байдлын арга хэмжээг ардчилсан нийгмийн эрх зүйн үндсэн зарчим, үнэт зүйлд нийцүүлэн хэрэгжүүлэхэд зорилготой юм.

  Батлан хамгаалах, харилцаа холбоо, тээвэр, эрчим хүчний салбар, хүнс, усан хангамж, эрүүл мэндийн салбарын ААН-үүд энэ хуулийн заалтад хамрагддаг. Хэрэв тухайн хөрөнгө оруулалт нь компанийн нийт хувь нийлүүлсэн хөрөнгө, хувьцааны 1/3 ба түүнээс дээш хувийг худалдан авахад чиглэгдэж байвал эрх бүхий байгууллагад заавал мэдэгдэж, зөвшөөрөл авах үүрэгтэй байна.

- Хөдөө аж ахуйн салбарт 3.5 га-аас дээш хэмжээтэй газар тариалангийн талбайг одоогийн эзэмшигчийн гэр бүлийн гишүүнээс өөр этгээд худалдан авах тохиолдолд концесс хийх шаардлагатай байдаг. Энэхүү концессын шаардлага нь худалдан авагчийн иргэний харьяаллаас үл хамаарна.

- Норвег Улсын усны эрчим хүчний салбарын хүрээнд томоохон буюу 10 мегаваттаас дээш хүчин чадалтай усан цахилгаан станцуудын өмчлөлийн 2/3-ыг төрийн мэдэлд байлгах шаардлага тусгагдсан байдаг. Бага оврын усан цахилгаан станц (10 мегаваттаас бага)-ыг зөвхөн тусгай зөвшөөрөлтэй этгээд эрхэлнэ.

- Аж үйлдвэрийн хамгийн чухал салбар болох газрын тос, байгалийн хийн салбарт Норвег Улсын газрын тосны лиценз эзэмшигч хуулийн этгээдийн ногдол хувь, хувьцааг худалдан авахад зөвхөн тус улсын Засгийн газрын зөвшөөрлөөр хийгддэг боловч энэ шаардлага нь гадаадын шууд хөрөнгө оруулалтад тусгайлан чиглэгддэггүй, дотоодын худалдан авагчдад мөн адил хамаардаг.

- Загас агнуурын хөлөг онгоц буюу, эсхүл далайн хөлөг онгоц эзэмшдэг компанийн ногдол хувь, хувьцааг зөвхөн Норвег улсын иргэн болон Норвег Улсын иргэдийн өмчлөлийн ААН худалдан авах эрхтэй байдаг байна.

- Норвег Улсын Өрсөлдөөний тухай хуулиар зах зээлийн өрсөлдөөнийг хангах, монополоос сэргийлэх үүднээс хөрөнгө оруулалт, ногдол хувь, хувьцааг худалдах, худалдан авах, хуулийн этгээдүүд нэгдэх, нийлэх зэрэг асуудлыг хянадаг байна.

[31] https://norway.dlapiper.com/en/news/guide-foreign-direct-investments-nordic-overview
[32] https://www.globallegalpost.com/lawoverborders/the-new-world-of-foreign-direct-investment-246697424/norway-1134233103

### Хөрөнгө оруулагчийн виз ба иргэншил

Норвег Улсад хөрөнгө оруулагчийн виз, хөрөнгө оруулалтын иргэншил авах гадаадын иргэд, түүний гэр бүлийн гишүүд нь дараах үндсэн нөхцөлийг хангахыг шаарддаг[33]. Үүнд:

- 18 насанд хүрсэн байх;
- гэмт хэрэг үйлдээгүй байх;
- 100,000 евро ба түүнээс дээш хэмжээний хөрөнгө оруулалт хийсэн байх;
- шаардлага хангасан бизнест хөрөнгө оруулалт хийж, ажлын байр бий болгосон байх.

Норвег Улсын иргэншил авахад одоо байгаа бизнесийн хүрээнд компани нээх гэсэн ганц сонголттой байдаг ба тухайн ААН-ийн үйл ажиллагаа нь дараах чиглэлийн аль нэг байж болно. Үүнд:

- мэдээллийн технологи;
- тээвэр;
- газрын тос, байгалийн хий;
- ногоон буюу цэвэр эрчим хүч;
- загас агнуур;
- далайн (maritime).

### Гадаадын иргэн үл хөдлөх хөрөнгө, газар эзэмших, өмчлөх

Норвег Улсад гадаадын хөрөнгө оруулагчид үл хөдлөх хөрөнгө эзэмшиж болно. Гэсэн хэдий ч тодорхой төрлийн үл хөдлөх хөрөнгийн өмчлөлийг хязгаарласан байдаг. Ой мод, уурхай, тариалангийн газар, хүрхрээ эзэмших, ашиглах эрхийг зөвхөн концессоор л авах боломжтой. Түрээсийн гэрээ нь 10 жилээс хэтрэхгүй бол гадаадын компаниудад арилжааны байгууламж, оффисын байр зэрэг үл хөдлөх хөрөнгө түрээслэхэд концессын хөнгөлөлт үзүүлэхгүй[34].

### Хөрөнгө оруулалтад олгох урамшуулал, дэмжлэг

“SkatteFUNN” хэмээх татварын урамшууллын схем нь Норвег Улсын худалдаа, аж үйлдвэрийн судалгаа, хөгжүүлэлтийг (R&D) дэмжих зорилготой Засгийн газрын ерөнхий хөтөлбөр юм. Урамшуулал нь хуулийн этгээдийн төлөх ёстой ААН-ийн албан татвараас хасагдах боломжтой татварын хөнгөлөлтийн хэлбэртэй байдаг ажээ.

Түүнчлэн тус улс тодорхой салбаруудад тухайлсан урамшуулал үзүүлдэг. Жишээлбэл, нүүрс, ус төрөгчийн үйлдвэрлэлийн салбарт онцгой албан татварын журам үйлчилдэг боловч тус салбарт хөрөнгө оруулалт хийвэл ердийн татварын хувь хэмжээгээр тооцдог. Ердийн ААН-ийн албан татварын хувь хэмжээ 22 хувь байдаг бол онцгой албан татварын хувь хэмжээ 71.8 хувь байдаг байна.

“Инновацлаг Норвег” (Innovation Norway), “Экспорт Кредит Норвег” (Export Credit Norway), ГИЕК (GIEK) зэрэг төрийн болон төрийн өмчит компаниуд хөрөнгө оруулалт хийсэн иргэн, хуулийн этгээдүүдэд бизнесийн зөвлөх үйлчилгээний болон бусад бизнесийг дэмжих үйчилгээ үзүүлдэг байна. “Инновацлаг Норвег” нь бизнесийн инноваци, хөгжил, худалдааг дэмжих зорилгоор байгуулагдсан төрийн байгууллага юм бол “Экспорт Кредит Норвег” нь төрийн өмчит экспортын санхүүжилтийн үйлчилгээний компани, ГИЕК нь экспортын баталгааны үйлчилгээний байгууллага юм.[35]

[33] https://www.lawyersnorway.eu/norway-citizenship-by-investment
[34] https://www.uhy.com/wp-content/uploads/Doing-Business-in-Norway.pdf
[35] https://www.uhy.com/wp-content/uploads/Doing-Business-in-Norway.pdf

## ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

**Авсрали Улс**

- Австралийн холбооны Засгийн газар, Гадаадын хөрөнгө оруулалтын газар: https://foreigninvestment.gov.au/guidance/general/key-concepts#screening
- Австралын холбооны улсын Татварын албаhttps://www.ato.gov.au/online-services/foreign-investors/online-services-for-foreign-investors
- Уугуул нутаг дэвсгэрийн тухай хууль, Native Title Act 1994 (ACT)
- Австралийн Үндэсний газрын эрхтэй холбоотой тайлангууд. Native Title Reports (1994-2012) and Social Justice Reports (2013-) on the Australian Human Rights Commission website for more information.
- Хөрөнгө оруулалтын газар: https://foreigninvestment.gov.au/sites/foreigninvestment.gov.au/files/2023-12/guidance-note-4-commercial-land-january-2024.pdf
- Иргэний харьяатын газар:

  https://www.henleyglobal.com/residence-investment/australia?page=ppc_Global_gsn_prod_res_australia_gti_tier4&gad_source=1&gclid=EAIaIQobChMI3-Por8HygwMV--0WBR2rQwovEAAYASAAEgIHLvD_BwE

**ХБНГУ**

- Germany Golden Visa: Requirements & How to get One

  https://www.ivisa.com/germany/blog/germany-golden-visa#what-is-the-german-residence-act?
- 2023 Investment Climate Statements:Germany

  https://www.state.gov/reports/2023-investment-climate-statements/germany/
- Foreign investment law and policy in Germany

  https://www.lexology.com/library/detail.aspx?g=55f81fb2-7e78-4a9c-95f4-9f87df04e80f
- Foreign Direct Investment Regimes:Germany

  https://iclg.com/practice-areas/foreign-direct-investment-regimes-laws-and-regulations/germany
- Corporate Taxation

  https://www.gtai.de/en/invest/investment-guide/corporate-taxation
- Tax Deductions

  https://www.gtai.de/en/invest/investment-guide/tax-deductions-561544

**Канад Улс**

- Канад Улсын хөрөнгө оруулалтын тухай хуул.
- https://ised-isde.canada.ca/site/investment-canada-act/en/what-investment-canada-act
- https://ised-isde.canada.ca/site/investment-canada-act/en/investment-canada-act/guidelines/guidelines-national-security-review-investments
- https://ised-isde.canada.ca/site/investment-canada-act/en/investment-canada-act/guidelines/guidelines-national-security-review-investments 8
- https://sobirovs.com/canada-investor-visa-learn-about-investment-immigration/
- https://sobirovs.com/business-immigration/business-owner-citizenship/
- https://sobirovs.com/canada-investor-visa-learn-about-investment-immigration/

- https://www.investcanada.ca/news/canadas-corporate-tax-system-explained

**БНСУ**

- Foreign investment promotion act:

  https://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=55490&type=part&key=19

- Invest korea:

  https://www.investkorea.org/ik-en/cntnts/i-334/web.do

**Нидерланд Улс**

- https://ind.nl/nl/formulieren/3095.pdf
- https://www.government.nl/topics/immigration-to-the-netherlands/options-for-entrepreneurs-and-employees-from-abroad/foreign-investors
- https://business.gov.nl/coming-to-the-netherlands/foreign-investors/foreign-investors/
- https://ind.nl/en/residence-permits/other-residence-permits/other-residence-permits#investing-in-the-netherlands

**Норвег Улс**

- https://lovdata.no/dokument/NLE/lov/2018-06-01-24/KAPITTEL_10#KAPITTEL_10
- https://konkurransetilsynet.no/legislation/?lang=en
- https://www.globallegalpost.com/lawoverborders/the-new-world-of-foreign-direct-investment-246697424/norway-1134233103
- https://iclg.com/practice-areas/foreign-direct-investment-regimes-laws-and-regulations/norway
- https://businessnorway.com/invest-in-norway
- https://www.uhy.com/wp-content/uploads/Doing-Business-in-Norway.pdf
- https://www.lawyersnorway.eu/norway-citizenship-by-investment